



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/д/д/З

Номгон

Г Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаатай  
танилцаж, хяналт тавих тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."м", Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай" 3/6 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Бичил уурхай бүхий сумдад Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай" 3/6 дугаар тогтоолын хэрэгжилттэй танилцаж, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүний томилолтын зардлыг шийдвэрлэж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал) , Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа (Б.Оюутболд), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Н.Бямбадорж), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Т.Алтангэрэл), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Ганзориг) нарт тус тус үүрэг болгосугай.


3.Бичил уурхай бүхий сумдад Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолын хэрэгжилттэй танилцаж, хяналт тавих ажлыг удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж аймгийн Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуй, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210029

Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын  
09-ний өдрийн А/443 дугаар захирамжийн  
1 дүгээр кавсгалт



**БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ  
ТАНИЛЦАЖ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Г.Энхбаяр- Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын  
асуудал хариуцсан орлогч

Гишүүд: Б. Оюутболд- Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа

М.Магваансүрэн- Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин дэд бүтэц,  
хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга

Д.Бат Эрдэнэ- Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын  
байцаагч Н.Бямбадорж- Мэргэжлийн хяналтын газрын дарга

Т.Алтангадас-Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах  
мөрдөгч

Б.Отгончимэг-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Геодези, зураг  
зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Б.Наранбаатар- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
Газар, газрын хэвлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын  
09-ний өдрийн А/443 дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ  
ТАНИЛЦАЖ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН  
УДИРДАМЖ

Зорилго: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай” 3/6 дугаар тогтоолын хэрэгжилттэй танилцаж, бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих.

Зорилт: Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаатай танилцаж, сум, орон нутгийн хэмжээнд тогтоолын хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгаад хяналт тавих

Хугацаа: 2021 оны 07 дугаар сарын 10-наас 2021 оны 07 дугаар сарын 17-ныг өдрийг хүртэл

Хамрах хүрээ: Баян-Овоо, Бөмбөгөр, Заг, Галуут, Бууцагаан, Өлзийт

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_